



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/137

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/151 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2.Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Батжаргал/-т даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
БӨГӨӨД БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН  
ГАЗРЫН ДАРГА А.ХИШИГБАЯР



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн тушаалын хавсралт



**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН 2021-2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ /2023-2025 он/**

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Үр дүн	Хөтөлбөрийн үйл ажиллагааны чиглэлтэй уядуулсан байдал	Санхүүгийн эх үүсвэр	Хариуцах байгууллага	Хэрэгжих хугацаа /он/
	<b>Зорилго</b>	Хөдөлмөр эрхэлж байгаа иргэн, ажилтны эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдлыг хамгаалах төрийн бодлого, зарчмыг хэрэгжүүлэх, үр нөлөөтэй нийгмийн түншлэл бүхий хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлагын тогтолцоог сайжруулах, ажилтан бүр эрүүл, аюулгүй хөдөлмөрийн орчин нөхцөлийг бий болгоход чиглэнэ.					
<b>Зорилт 1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, уялдаа холбоог нь сайжруулах</b>							
1	ОУХБ-ын аж үйлдвэр болон худалдаан дахь хөдөлмөрийн хяналтын тухай 81, хөдөө аж ахуй дахь хөдөлмөрийн хяналтын тухай 129, ХАБЭА-н суурь тогтолцооны 187 дугаар конвенцод нэгдэх бэлтгэл ажлыг хангах	Конвенц - 3	Судалгаа хийгдсэн байна.  Конвенцод нэгдэж, хууль эрх зүйн орчин сайжирсан байна.	1.1, 1.4	ОУ-ын төсөл хөтөлбөр	ХНХЯ	2023-2025 он
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийг шинэчлэн боловсруулах хуулийн төслийг бэлтгэх	Хуулийн төсөл - 1	Хуулийн эрх зүйн орчин, уялдаа холбоо сайжирсан байна.	1.2, 1.3, 1.4	Улсын төсөв ОУ-ын төсөл хөтөлбөр	ХНХЯ	2023 -2024
3	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийг шинэчлэн батлуулах	Дүрэм - 1	ҮОХХ-ын бүртгэл, мэдээлэх зохицуулалт сайжирсан байна.	1.2, 1.3, 1.4	-	ХНХЯ	2023 -2024
4	ХАБЭА-н сургалт зохион байгуулах, шалгалт авах журмыг шинэчлэн батлуулах	Журам -1	ХАБЭА-н сургалтын зохицуулалт сайжирсан байна	1.2, 1.3, 1.4	-	ХНХЯ ХАБЭМТ	2023 он

5	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журмыг шинэчлэн сайжруулах	Журам – 1	Журам идэвхтэй урьдчилан сэргийлэлт, эрсдэлд суурилсан зарчмаар сайжирсан байна.	1.1,1.4,	-	ХНХЯ	2023 он
6	Ажлын байранд дахь тоосны өртөлтөөс ажилтны эрүүл мэндийг хамгаалахад мөрдөх техникийн зохицуулалтыг батлуулах	Техникийн зохицуулалтыг батлуулсан байна	Тоосоор үүсгэгдэг мэргэжлээс шалтгаалсан өвчний идэвхтэй урьдчилан сэргийлэлтэд мөрдөх техникийн зохицуулалт батлагдсан байна.	1.1, 1.2, 1.5	ҮОМШӨДС	ХНХЯ	2023 он
7	Асбесттэй аюулгүй харьцах ажлын техникийн зохицуулалтыг боловсруулах	Техникийн зохицуулалтын - 1	Абестийг орлуулах материалын хэрэглээг дэмжих, асбестийг аюулгүй зайлуулах, өртөлтийг үнэлгээ, эрсдэлтэй ажилтнуудын эрүүл мэндийн үзлэг, тандалт хийх асуудлыг багтаасан техникийн зохицуулалтын төсөл бэлэн болсон байна.	1.1, 1.2	ҮОМШӨДС	ХНХЯ	2024 он
8	Хязгаарлагдмал орчинд аюулгүй ажиллагааны техникийн зохицуулалтыг боловсруулах	Техникийн зохицуулалтын - 1	Хязгаарлагдмал орчинд ажиллагсдын аюулгүй байдлыг хангах техникийн зохицуулалтын төсөл бэлэн болсон байна.	1.1,1.3, 1.4	ҮОМШӨДС	ХНХЯ	2023-2024
9	Ажилтны эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийн журмыг шинэчлэх	Журам -1	Өндөр эрсдэлтэй ажиллагчдын дунд мэргэжлээс шалтгаалсан өвчнийг эрт илрүүлэх, бүртгэх, мэдээлэх, тандах, ажил мэргэжлийн тохироог хийх асуудлыг багтаасан шинэчилсэн журам батлагдсан байна.	1.1, 1.3, 2.4	-	ЭМЯ ХНХЯ	2023-2024
10	Мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалтыг шинэчлэн батлуулах	Жагсаалт - 1	Асбесттай холбоотой өвчнийг МШӨ-ний жагсаалтад багтаасан байна.	1.1, 1.3	-	ХНХЯ ЭМЯ	2024 он
<b>Зорилт 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн удирдлага зохион байгуулалт, хамтын ажиллагааг сайжруулах</b>							
1	Үндэсний хэмжээнд ХАБЭА-н удирдлага зохион байгуулалтад оролцдог төрийн байгууллагуудын чиг	Үнэлгээ хийгдсэн байна.	Төрийн байгууллагуудын ХАБЭА-н талаарх чиг үүргийн	1.2	ОУ-ын төсөл хөтөлбөр	ХНХЯ	2024 он

	үүргийн хувиарлалт, хэрэгжилтэд нь үнэлгээ хийж, завсардлын дүн шинжилгээ (Gap-Analysis) хийх		оновчтой хувиарлалт, оролцоог нэмэгдүүлнэ.				
2	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний өндөр эрсдэлтэй аж ахуйн нэгжүүдэд зориулсан "ХАБЭМ-ийн эрсдэлийн харилцаа, тандалтын цахим систем"-ийн аргачлал, загварын саналыг боловсруулах	Цахим систем бий болсон байна.	"ХАБЭМ-ийн эрсдэлийн харилцаа, тандалтын цахим систем"-ийн аргачлал, загварын саналыг гаргасан байна.	2.3	ОУ-ын төсөл хөтөлбөр	ХНХЯ ЦХХХЯ	2024-2025
3	Бичил бизнес, жижиг үйлдвэр, албан бус хөдөлмөр эрхлэгч нарт зориулсан ХАБЭМ-ийн эрсдэлийн үнэлгээ, хяналтын аргачлал боловсруулж, хэрэгжилтийг нь дэмжих	ХАБЭМ-ийн эрсдэлийн үнэлгээний аргачал боловсуулагдсан байна.	Бичил бизнес, жижиг үйлдвэр, албан бус хөдөлмөр эрхлэгч нар ҮОМШӨ-ийн урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ.	3.1	ҮОМШӨДС	ХНХЯ	2023-2024
4	ХАБЭА-н салбар хороо, зөвлөлийн гишүүдийн чадавхыг бэхжүүлэх, сургалт зохион байгуулах, үйл ажиллагааг тогтмолжуулах	ХАБЭМ-ийн оролцогч талуудыг дэмжсэн байна.	Салбарын яам, орон нутаг, ажил олгогч, ажилтны төлөөлөл ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэхэд оролцоо нэмэгдсэн байна.	1.3, 4.1	ОУХБ	ХНХЯ	2023-2025 он
5	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний чуулган зохион байгуулах	Чуулганы бэлтгэл ажлыг хангах	Үндэсний хэмжээнд зохион байгуулсан байна.	2.1, 4.1	ҮОМШӨДС	ХНХЯ ХАБЭМТ ХАБЭА-н үндэсний хороо	2023 он

**Зорилт 3. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хөдөлмөрийн хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх**

1	Асбест хэрэглэдэг аж ахуйн нэгж байгууллагуудад ХАБЭА-н үндэсний хорооноос батлагдсан "Асбесттай харьцах аюулгүй ажиллагааны заавар"-ын хэрэгжилтийн хяналт үнэлгээ хийх	Хяналт үнэлгээний тайлан гарсан байна.	Асбесттай холбоотой өвчний урьдчилан сэргийлэх арга хэмжээг идэвхжүүлнэ.	1.9	Улсын төсөв	ХНХЯ	2023-2025
2	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийдэг итгэмжлэл бүхий байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөмж хүргүүлэх	Хяналт зохион байгуулж, зөвлөмж хүргүүлсэн байна.	Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний мөрөөр МШӨ-өөс урьдчилан сэргийлэх үр нөлөө сайжирсан байна.	4.2	Улсын төсөв	ХНХЯ, ХАБЭМТ	2023-2025
3	Мэргэжлээс шалтгаалсан өвчний хөдөлмөрийн чадвар алдалтыг	Хяналт, шалгалт зохион байгуулсан байна.	МШӨ, сэтгэцийн салбар зөвлөл, орон нутгийн	2.4, 1.6, 2.1	ҮОМШӨДС Улсын төсөв	ХНХЯ ЭМЯ,	2023-2025

	тогтоох үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх		комиссийн үйл ажиллагаа сайжруулсан байна.				
4	ХАБЭА-н сургалтын журмын хэрэгжилт, ХАБЭА-н сургалтын байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж, дүгнэлт гаргах	Хяналт-үнэлгээ хийсэн байх	Сургалтын чанар, хүртээмж нэмэгдсэн байна.	1.2, 1.4, 2.1	Улсын төсөв	ХНХЯ, ХАБЭМТ	2023-2025
5	Хөдөлмөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглож, хяналт тавьж ажиллах	Дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглосон байна.	ААНБ бүр эрүүл ажлын байртай болсон байна.	1.3, 3.1, 3.4	-	ХНХЯ, Аймаг, нийслэл, дүүргийн ХХҮГ, Хэлтэс	Жил бүр
6	Эрсдэл өндөртэй аж ахуйн нэгж, байгууллагыг ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээнд хамрагдах хувийг нэмэгдүүлэх	Хөдөлмөрийн нөхцөл сайжирсан байна.	ААНБ-ын үйл ажиллагаа сайжирсан байна.	4.2, 4.3	ОУ-ын төсөл, хөтөлбөр ҮОМШӨДС	ХНХЯ ХАБЭМТ	2024-2025
7	Төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын явцад хөдөө аж ахуй, бичил бизнес, хувиараа хөдөлмөр эрхлэгчэд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зөвлөмж, зөвлөгөө өгч ажиллах	Зөвлөмж гаргаж, хэрэгжилтийг хангасан байна.	ААНБ, иргэдийн мэдлэг сайжирсан байна.	3.4	Улсын төсөв	ХНХЯ, МАОЭНХ, ААНБ-ууд	Жил бүр
8	Аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд ХАБЭА-н бүтэц, ажилтан, зөвлөл ажиллуулах нормативын хэрэгжилтэд үнэлгээ хийх	Орон тооны ажилтантай болсон байна.	Журмын хэрэгжилт хангагдсан байна.	2.1, 4.1	Улсын болон орон нутгийн төсөв	ХНХЯ, Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга,	2023-2025
<b>Зорилт 4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн менежментийн тогтолцоог боловсронгуй болгож, аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд мэргэжлээс шалтгаалсан өвчний урьдчилан сэргийлэлтийг сайжруулах</b>							
1	Хөдөө аж ахуйн салбарын бичил, жижиг, дунд бизнес, албан бус хөдөлмөр эрхлэгчдэд зориулсан сургалтын ХАБЭМ-ийн гарын авлага боловсруулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	Гарын авлага гаргасан байна.	Малчин, бичил бизнес, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг сайжирсан байна.	1.4, 1.5	ОУХБ ҮОМШӨДС	ХНХЯ	2023-2024

2	Хөдөө аж ахуйн салбарын бичил, жижиг, дунд бизнес, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг орон нутгийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх	21 аймаг, 9 дүүрэгт сургалт зохион байгуулсан байна.	Малчин, бичил бизнес, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг сайжирсан байна.	1.4, 1.5, 1.6,	Улсын болон орон нутгийн төсөв	Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга, ХАБЭА-н зөвлөл	2023-2025
4	ҮОМШӨ-өөс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэд, даатгуулагч, ажил олгогчдод хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нийгмийн даатгалын ач холбогдлын талаар сурталчилгаа зохион байгуулах	Сургалт, сурталчилгаа зохион байгуулж, сануулга мессежийг гар утсанд нь илгээдэг болно.	Даатгуулагч ҮОМШӨ-нөөс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэг сайжирсан байна.	1.4, 1.5, 1.6,	ҮОМШӨДС	НДЕГ	2023-2025
5	Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах арга хэмжээг жил бүр зохион байгуулах	Болзолт уралдааныг жил бүр журмыг дагуу зохион байгуулсан байна.	Шалгарсан ААНБ-ыг урамшуулан, сайн туршлагыг түгээсэн байна.	4.3	ҮОМШӨДС	ХАБЭМТ	Жил бүр
6	Аж ахуйн нэгж, байгууллага бүр тодорхой хугацаанд ажлын байрны эрсдэлийн болон хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийж хэвшсэн байх	Үнэлгээ хийгдсэн байна.	Ослыг урьдчилан харж арилгасан байна.	1.6, 2.1, 3.4, 4.4	ААНБ-ын төсөв	МАОЭНХ ААНБ-ууд	2023-2025
7	ХАБЭА-н сарын аяныг орон нутаг, салбарын түвшинд зохион байгуулж, ҮОМШӨ-нөөс урьдчилан сэргийлэх чиглэлэр шторк, контент, тараах материал, санал зөвлөмжийг бэлтгэн хэвлүүлэх, цахимаар сурталчлах, нийтэд түгээх	ААНБ, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, бичил бизнес эрхлэгчдэд сургалт зохион байгуулсан байна.	Сайн туршлага соёлыг түгээж, нийгмийн түршлэлийн оролцоог нэмэгдүүлсэн байна.	3.4, 2.1	ОУХБ	ХНХЯ, ААНБ-ууд	Жил бүр
<b>Зорилт 5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн боловсрол, сургалт, статистик эрдэм шинжилгээнд дэмжлэг үзүүлэх</b>							
1	Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бүртгэх мэдээлэх журмыг шинэчлэн боловсруулж, албан ёсны статистик мэдээлэлтэй болох	Ажлын хэсэг байгуулж, журмын төслийн боловсруулах	Журам батлагдаж, мэдээллийг шинэчилсэн байна.	1.7, 5.1, 1.6	ҮОМШӨДС	ХНХЯ ХАБЭМТ ҮСХ	2023-2024
2	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим бүртгэлийн /om.inspection.mn/ системийг шинэчлэн хөгжүүлж, төрийн цахим мэдээлэл солилцох системд холбох, улсын байцаагчдад сургалт зохион байгуулах	Цахим хөгжүүлэлтийн холболт хийгдсэн байна.	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын статистик бүртгэл сайжирсан байна.	1.6, 1.8, 4.5, 4.6, 5.1	ОУХБ	ХНХЯ	2023-2024

